



БАТЛАВ:
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш. БАЯНМӨНХ



БАТЛАВ:
ГАЛТ ЦАМХАГ ХХК-ийн
ЗАХИРАЛ О.ЭНХБАТ

G250 МАРКЫН КОМПРЕССОРЫН СЭЛБЭГ
ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар № 54/2022

2022 оны 05-р сарын 02 өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас “АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх нөгөө талаас “ГАЛТ ЦАМХАГ” ХХК-ийн захирал О.Энхбат /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1 Нийлүүлэгч нь “G250 маркын компрессорын сэлбэг” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох нэгдүгээр хавсралтанд заасан нэр төрөл, нэг бүрийн үнэ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн агуулахад нийлүүлнэ.

Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

2.1 Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш 45 хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

- 3.1 Энэ гэрээний нийт үнэ 128,229,648 /нэг зуун хорин найман сая хоёр зуун хорин есөн мянга зургаан зуун дөчин найм /-н төгрөг бөгөөд “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн агуулахад хүргэх, тээврийн зардал, НӨАТ бүгд шингэсэн байна.
- 3.2 Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 3.3 Төлбөрийг бараа нийлүүлж дууссан гүйцэтгэлээр олгоно.
- 3.4 Барааг хүлээн авсаны дараа бараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн акт, нийлүүлэгчийн нэхэмжлэлийг үндэслэн 90 хоногийн дотор төлбөрийг нийлүүлэгчийн Хас банкны 5009697612 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

4.1 Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.

- 4.2 Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.
- 4.3 Барааг “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн агуулахад ирсний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.
- 4.4 Барааг хугацаандаа нийлүүлж чадаагүй тохиолдолд түүнээс гарах хохирлыг нийлүүлэгч тал бүрэн хариуцна.
- 4.5 Захиалагчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн Зуухан цехийн дарга Э.Ариунболд хариуцан ажиллана. Утас-99727172
- 4.6 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг “Галт цамхаг” ХХК-ийн инженер Х.Бат-Өлзий хариуцан ажиллана. Утас-88099520

Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол

- 5.1 Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2 Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг Захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.3 Нийлүүлэгч нь нийлүүлсэн барааг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш 6 сарын баталгаа гаргана. Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан гэмтэл согогийг өөрийн зардлаар засаж залруулах үүрэгтэй.

Зургаа. Бараа хүлээн авах

- 6.1 Нийлүүлэгч нь ачигдсан барааг Улаанбаатар хотын “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн агуулахад бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2 Нийлүүлэгч нь барааг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй
- 7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд 5 хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

Найм. Гэрээг цуцлах үндэслэл

- 8.1 Нийлүүлэгч нь бараа материал нийлүүлэх энэхүү гэрээнд зааснаас 45 хоног хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ авахгүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах ба баталгааг буцаан олгохгүй.

8.2 Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

Ес. Бусад нөхцөл

- 9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, Захиалагч 2 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХЖ-ИЙН
АЖ АХУЙ ХАНГАМЖ ЭРХЭЛСЭН ДЭД
ЗАХИРАЛ Б.УРТНАСАН
Гарын үсэг: 

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧИЙН АЖИЛ ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ө.УДВАЛ
Гарын үсэг: 

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Г. ЭРДЭНЭБИЛЭГ
Гарын үсэг: 

ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА
Э.АРИУНБОЛД
Гарын үсэг: 

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
Г. САРУУЛ
Гарын үсэг: 

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:
ЦАХИМ ХУДАЛДАН АВАЛТ ХАРИУЦСАН
АЖИЛТАН Г.БАЯРЧИМЭГ
Гарын үсэг: 

Хаяг: Улаанбаатар хот
Баянзүрх дүүрэг, 8-р хороо, ус 15-1-1
Утас: 77111251 РД:6021646

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГАЛТ ЦАМХАГ ХХК-ИЙН

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР П.ТӨМӨРЧӨДӨР

Гарын үсэг: 

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
11-р хороо, Алтайн гудамж өөрийн байр
Утас: 88014450 РД: 5336015

54/2002

Тоот гэрээний хавсралт

Бараа нийлүүлэх үнийн санал

Д/д	Барааны нэр	Бараан тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ /НӨАТ/ орсон
1	Сеператор	1614952100	Хятад	Ширхэг	2	7,946,089	15,892,178
2	Тосны шүүрний корпусны жийрэг	663210777	Хятад	Ком	3	304,538.33	913,615
3	Компрессорын тос	2901052200	Хятад	Литр	400	54,894.64	21,957,857
4	Компрессорын агаар шүүгч	1621507500	Хятад	Ширхэг	8	2,361,000	18,888,001
5	Компрессорын тосны шүүгч	1621737800	Хятад	ширхэг	9	992,253.2	8,930,279
6	Даралт бууруулах хавхлагын ком	2906056300	Хятад	Ком	3	989,156	2,967,468
7	Нам даралтын хавхлагын ком	2906020100	Хятад	Ком	3	647,841	1,943,523
8	Юүлэх хаалтны ком	2901074900	Хятад	Ком	3	647,841	1,943,523
9	Термостат ком	161975600	Хятад	Ком	3	716,258.7	2,148,776
10	Хаалт суурилуулах ком	2906059100	Хятад	Ком	3	1,091,202	3,273,607
11	Тунадас гадагшлуулах ком	2906070100	Хятад	Ком	3	7,093,782	21,281,346
12	Хатаагчийн шүүлтүүр	PC40	Хятад	Ширхэг	8	1,150,923	9,207,383
13	Тохируулах хаалтны корпус	1621039900	Хятад	Ком	2	2,318,854	4,637,707
14	Компрессорын холбох хэрэгсэл жийрэг	1614950900	Хятад	ком	4	2,318,854	9,275,414
		1614951100	Хятад	Ширхэг	3	414,081	1,242,243
		1614951300	Хятад	Ширхэг	3	414,081	1,242,243
		1614951400	Хятад	Ширхэг	3	414,081	1,242,243
		1614951000	Хятад	Ширхэг	3	414,081	1,242,243
15							128,229,648

Амгалан дулааны станц ТӨХК-ийн

Зуухан цехийн дарга

Галт цамхаг ХХК-ийн инженер

Э.Ариунболд

Х.Бат-Өлзий